



Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны
дугаар тушаалын 11 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар

Нэгжийн нэр:

Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологи, телемедицин хөгжүүлэхэд мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн мэдээллийн технологи, телемедицинийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалтаар хангах.
2. Салбарын мэдээллийн технологийн дэд бүтцийг бэхжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Мэдээллийн технологийн талаарх хууль тогтоомж, тогтоол тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих; 2. Салбарын хэмжээний телемедициний программ хангамж болон бусад тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, бэлэн байдлыг хангах; 3. Төгсөлтийн дараах зайны сургалт, цахим шалгалтыг явуулах нөхцлийг хангах; 4. Телемедициний сүлжээ, програм хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар харьяа байгууллагын мэргэжилтнүүдийг арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах, гарын авлага, материалыг боловсруулах; 5. Телемедициний үндэсний сүлжээ ашиглан явуулсан зөвлөгөө, эмчилгээний талаарх эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийг улирал, жилээр хүлээн авч нэгтгэн, нэгдсэн тайлан гаргах; 6. Телемедициний сүлжээний үйл ажиллагааны мэдээний санг бий болгож, баяжуулах, бусад мэдээний сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. 7. Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийг 	<p>Хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Бэлэн байдлыг ханган ажилласан байна.</p> <p>Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.</p> <p>Тайлан мэдээг хугацаанд нь гаргасан байна.</p> <p>Мэдээний сангийн баяжилт хийгдсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>



	<p>өргөжүүлэх, хэвийн үйл ажиллагааг ханган гжиллах;</p> <p>8. Салбарын хэмжээнд мэдээллийн технологийн техник болон программ хангамжийн тогтвортой байдлыг хангах;</p> <p>9. Байгууллагын дотоод сүлжээ, техник хангамж болон програм хангамжийн бэлэн байдлыг хангаж;</p> <p>10. Хувь хүн болон байгууллагын эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах;</p> <p>11. Байгууллагуудын цахим хуудсын тогтвортой байдлыг ханган мэдээлэл байршуулах, баяжилт, өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.</p>	<p>Бэлэн байдал хангагдсан байна.</p> <p>Мэдээллийн аюулгүй байдлыг хангагдсан байна.</p> <p>Цахим хуудсанд мэдээ мэдээллийг тогтмол байршуулсан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1. БОЭТ, хувийн хэвшил, сум, өрхийн эмнэлэг, ЭМТ-ийн программ хангамж, компьютер, техник хэрэгслийн гэмтлийг тухай бүр засварлах;</p> <p>2. БОЭТ, хувийн хэвшил, сум, өрхийн эмнэлэг, ЭМТ-ийг интернетийн сүлжээнд холбох, хэвийн үйл ажиллагааг хангах талаар заавар, зөвлөмж өгөх;</p> <p>3. БОЭТ, хувийн хэвшил, сум, өрхийн эмнэлэг, ЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдэд сургалт явуулах, заавар, зөвлөмж өгөх.</p>	<p>Хэрэглэгчдэд ээлтэй, эрүүл мэндийн мэдээллийн дэд бүтэц бий болж, үйл ажиллагаа жигдэрсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1. Эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;</p> <p>2. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг мөрдөж ажиллах;</p> <p>3. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох;</p> <p>4. Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрдөж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилтээр, Стандартыг мөрдөж ажилласан байна.</p> <p>Оролцсон арга хэмжээний тоогоор, Ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан байна.</p> <p>Хууль тогтоомжийн хэрэгжилтээр.</p> <p>Хэрэгжилтийн</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>



	5. Жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах;	хувиар,	Г
	6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцан ажиллах.		Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	Мэдээлэл харилцаа, холбооны технологи /0613/.	
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачилгатай ажиллах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг

	байх; - нээлттэй, шударга байх; - бусад.
Бусад	- ергэн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх, - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:
Байхгүй.

Бусад харилцах субъект:

- Эрүүл мэндийн яам, агентлагийн холбогдох мэргэжилтэн,
- Аймгийн Засаг даргын орлогч,
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,
- Эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд,
- Иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.Оюунтуяа Н.ОЮУНТУЯА

20... оны дугаар сарын-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:
19 10 30

Дугаар: 201



Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019.11.22

Дугаар: а/49

ДАРГА ИЮЕ0007

Д.ШИВААННҮРДЭВ

2019 оны 11 дугаар сарын 22-ны өдөр